

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 03-ны өдөр

№ 20/09

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журмын 2 дугаар бүлгийн 2.1, 2.3, 2.5 дахь заалт, 3 дугаар бүлэг, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурлыг 2020 оны 03 сарын 28-ны өдрийн 12:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Корпорейт Конвеншн Центрийн эвент танхимд зохион байгуулж хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - 2.1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
 - 2.2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - 2.3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
 - 2.4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсвийг батлах;
 - 2.5. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэн батлах эсэх асуудал;
 - 2.6. Компанийн өөрийн хөрөнгийг хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх эсэх асуудлыг хэлэлцэн батлах.
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг энэхүү тогтоолын Хавсралт No1-ийн дагуу баталж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д 2020 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн дотор хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ж.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай зарыг энэхүү тогтоолын Хавсралт No2-ын дагуу баталж, 2020 оны 2 дугаар сарын 10 болон 25-ны өдрүүдэд Компанийн цахим хуудас, өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлэг түгээдэг радио, телевиз болон Монголын хөрөнгийн бирж ХК-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг энэхүү тогтоолын Хавсралт 3-ын дагуу баталж, баримт бичгийг 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор бэлтгэн, 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хүргүүлж танилцах бололцоогоор хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигч нь энэхүү тогтоолын Хавсралт No3-т заасан баримт бичгийг 2020 оны 2 сарын 10-ны өдрөөс эхлэн 2020 оны 03 сарын 27-ны өдөр хүртэлх хугацаанд ажлын

одруудад 09:30-17:30 цагийн хооронд Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж, Сувд төвийн I давхарт ирж танилцаж болохыг мэдэгдсүгэй.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар /-ыг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийг ЛэндМН ББСБ ХК-ийн дараахь ажилтны бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

9.1. Комиссын дарга:

М.Түвшинжаргал Санхүү, үйл ажиллагаа хариуцсан захирал

9.2. Гишүүд:

Б.Пүрэвсүрэн	Маркетингийн албаны менежер
О.Энэрэл	Маркетингийн менежер
Ц.Баатарцогт	Маркетингийн менежер
Б.Батбилэг	Маркетингийн менежер
Г.Мөнх-Эрдэнэ	Албаны менежер
О.Батзаяа	Харилцагчийн үйлчилгээний төвийн менежер
Э.Эрэлхэгзориг	Мэдээллийн технологийн инженер
Г.Уранчимэг	Төслийн менежер
Э.Насанжаргал	Системийн ахлах инженер
Б.Оюунболд	Хуулийн зөвлөх
Ж.Мөнхцэцэг	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дарга, гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

10.1. Комиссын дарга:

С.Батбуян “ЭмДи’Эс Хаан Лекс” ХХН, Партнер

10.2. Гишүүд:

М.Нямсүрэн	Хууль, хянан нийцүүлэлт хариуцсан мэргэжилтэн
М.Номин	Санхүүгийн шинжээч
Г.Оргилмаа	Хуулийн зөвлөх

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс саналын хуудасны дагуу санал авч, түүнийг үндэслэн хурлын тогтоолыг гаргахыг Хурлын даргад үүрэг болгосугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг энэхүү тогтоолын Хавсралт No4-ийн дагуу, санал авах хуудсыг Хавсралт 5а, 5б, 5в-ын дагуу тус тус баталсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудсыг брокер, дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт санал авах ажлыг зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисст үүрэг болгож, тэдгээр саналын хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 18.00 цагаар тасалбар болгохоор тогтоосугай.
14. Компанийн энгийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчээс Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад оруулах саналыг 2020 оны 3 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл хүлээн авахыг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д үүрэг болгосугай.

15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахтай холбогдон гарах зардлын төсвийг баталж, санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д зөвшөөрсүгэй.
16. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Ж.Мөнхцэцэг/, Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар /-д тус тус үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

[Handwritten signature]

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

**“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 2 сарын 03-ны өдрийн 20/сэ тоот тогтоолын
ХАВСРАЛТ №1**



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“ЛэндМН ББСБ” ХК
Хаяг, утас:	Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж, Сувд төв, 201 тоот
Хурал хуралдах өдөр, цаг:	2020 оны 3 сарын 28-ны өдөр 12:00 цаг
Хурал хуралдах газар: /хаяг, байршил/	Хан-Уул дүүрэг, Корпорейт Конвеншн Центр, эвент танхим
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2020 оны 2 дугаар сарын 03-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2020 оны 2 дугаар сарын 10-ны өдөр
Бүртгэлийн өдөр:	2020 оны 2 дугаар сарын 25-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2020 оны 2 дугаар сарын 14-ний өдөр
Хүргүүлсэн огноо:	2020 оны 2 дугаар сарын 05-ны өдөр
Хурлын дарга:	Гүйцэтгэх захирал О.Болдбаатар
Тооллогын комиссын дарга: Гишүүд:	- “ЭмДиЭс Хаан Лекс” ХХН, Партнер С.Батбуян - ЛэндМН ББСБ ХК, Хууль, хянан нийцүүлэлт хариуцсан мэргэжилтэн М.Нямсүрэн - ЛэндМН ББСБ ХК, Санхүүгийн шинжээч М.Номин - Анд Системс ХХК, Хуулийн зөвлөх Г.Оргилмаа
Баримт, бичгийн жагсаалт: (хавсралтаар)	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн __ тоот тогтоол; - Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарын загвар; - Хувьцаа эзэмшигчдийн хуралдааны дэг; - “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны тайлан; - “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2019 оны санхүүгийн аудитлагдсан тайлан; - “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн танилцуулга;

	- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсвийн санал; - Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийн төсөл; - Хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх санал оруулах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 03-ны одрийн __ тоот тогтоол; - Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудасны загварууд.
Баримт, бичгийн хуудсын тоо	- __ хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОММИССЫН ДАРГА



М.ТҮВШИНЖАРГАЛ

2020 оны 02 сарын 05-ны өдөр

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 2 сарын 03-ны өдрийн 207/09 тоот тогтоолын
ХАВСРАЛТ №2



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ЗАР**

Компанийн нэр:	“ЛэндМН ББСБ” ХК
Хаяг, утас:	Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж, Сувд төв, 201 тоот
Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдөр, цаг:	2020 оны 03 сарын 28-ны өдөр 12:00 цаг
Хурал хуралдах газар: /хаяг, байршил/	Хан-Уул дүүрэг, Корпорейт Конвеншн Центр, эвент танхим
Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:	2020 оны 2 дугаар сарын 25-ны өдөр
Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал:	1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах; 2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах; 3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай; 4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсвийг батлах; 5. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэн батлах эсэх асуудал; 6. Компанийн өөрийн хөрөнгийг хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх эсэх асуудлыг хэлэлцэн батлах.
Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:	Хувьцаа эзэмшигчид 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хооронд өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хандан, эсхүл Компанийн байранд ирж хурлын баримт бичигтэй танилцаж болно. Хурал зохион байгуулах комисс нь Даваа-Баасан гаригт 09:30-12:30, 13:30-17:30 цагийн хооронд ажиллана.
Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн мэдээлэл:	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн Санхүү, үйл ажиллагаа хариуцсан захирал М.Түвшинжаргал, tuvshinjargal@lend.mn - Маркетингийн албаны менежер Б.Пүрэвсүрэн, marketing@lend.mn

	- Маркетингийн менежер О.Энэрэл, marketing@lend.mn - Маркетингийн албаны менежер Ц.Баатарцогт, marketing@lend.mn - Маркетингийн албаны менежер Б.Батбилэг, marketing@lend.mn - Албаны менежер Г.Мөнх-Эрдэнэ, munkherdene@lend.mn - Харилцагчийн үйлчилгээний төвийн менежер О.Батзаяа, batzaya@lend.mn - Мэдээллийн технологийн инженер Э.Эрэлхэгзориг, erelkhegzorig@lend.mn - ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ж.Мөнхцэцэг, board@lend.mn
Нэмэлт мэдээлэл	Компанийн энгийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчээс Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад оруулах нэмэлт саналыг 2020 оны 3 дугаар сарын 02-ны өдөр хүртэл Хурал зохион байгуулах комиссын дарга болон Компанийн Толоолон Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга нар хүлээн авна. Тус хугацаа өнгөрсөн тохиолдолд хувьцаа эзэмшигч нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудал болон Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаар санал гаргах эрхгүй болохыг анхаарна уу.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 2 сарын 03-ны өдрийн 05/03 тоот тогтоолын
ХАВСРАЛТ №3



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ
ХОЛБООТОЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

	Баримт бичгийн жагсаалт
1	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн __ тоот тогтоол;
2	- Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар;
3	- Хувьцаа эзэмшигчдийн хуралдааны дэг;
4	- Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудас;
5	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны тайлан;
6	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
7	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2019 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг дүгнэсэн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 сарын 03-ны өдрийн __ тоот тогтоол;
8	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүний танилцуулга;
9	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн танилцуулга;
10	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсвийн санал;
11	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрэмд оруулах өөрчлөлтийн төсөл;
12	- Өөрийн хөрөнгийг хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх санал оруулах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 02 сарын 03-ны өдрийн __ тоот тогтоол
13	- Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл;
14	- Хувьцаа эзэмшигчдийн хурлын нэмэлт материал.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 2 сарын 03-ны өдрийн 20/сз тоот тогтоолын
ХАВСРАЛТ №4

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

No	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах
1	Хурлын ирц бүртгэх	11:30-12:00	Тооллогын комисс
2	Хурлын ирцийг мэдээлэх	12:00-12:05	Тооллогын комисс
3	Хурлыг нээх, хурлын дэг танилцуулах	12:05-12:15	Хурлын дарга
4	Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах	12:15-12:30	Гүйцэтгэх захирал
5	Компанийн ТУЗ-ийн тайлан, 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх	12:30-13:00	ТУЗ-ийн дарга
6	Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн, ердийн гишүүнд нэр дэвшигчийг танилцуулах	13:00-13:15	ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин, урамшууллын хорооны дарга
7	Компанийн ТУЗ-ийн 2020 оны төсвийн саналыг танилцуулах	13:15-13:30	Гүйцэтгэх захирал
8	Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийн төслийг танилцуулах	13:30-13:45	Гүйцэтгэх захирал
9	Компанийн өөрийн хөрөнгийг хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх, ТУЗ-д зохих эрхийг олгох	13:45-14:00	ТУЗ-ийн дарга
10	Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт	14:00-14:20	Хурлын дарга
11	Хэлэлцэж байгаа асуудлуудаар санал хураах	14:20-14:40	Хурлын дарга, Тооллогын комисс
12	Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах	15:00-15:15	Тооллогын комиссын дарга
13	Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг тусган, танилцуулж, батлуулах	15:15-15:30	Хурлын дарга, Хурал зохион байгуулах комиссын дарга

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 2 сарын 03-ны өдрийн 20/03 тоот тогтоолын
ХАВСРАЛТ №5а



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: _____ Энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг): _____

Үнэт цаасны дансны дугаар: _____

Бүртгэсэн ҮЦК-ийн нэр: _____

Брокерийн овог, нэр: _____

№	Хэлэлцэн батлах асуудал	Хувьцаа эзэмшигчийн санал			
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан бол таны өгөх санал
1	Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах				
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны төсвийг батлах				
3	Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийн саналыг батлах				
3.1	8.4.12.ТУЗ-өөс бөлөвөрүүлсэн компанийн жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайланг хэлэлцэн батлах;				
3.2	8.5.7. Хувьцааг нэгтгэх буюу хуваах;				
3.3	8.11.Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс өмнө байж болохгүй.				
3.4	9.6.11.компанийн салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах, хөрөнгө оруулалт хийх замаар компани үүсгэн байгуулах, хууль болон нийтээр дагаж мөрдөх				

	журамд заасан хүрээнд бусад хуулийн этгээдийн хувь эзэмшлийг худалдан авах, компанийг төлөөлж үүсгэн байгуулагч, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг томилох, бүрэн эрхийг нь тодорхойлох;				
3.5	9.7. ТУЗ нь хууль тогтоомжид зөвхөн ТУЗ хэрэгжүүлэхээр зааснаас бусад бүрэн эрхээ Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний хүрээнд хариуцуулан гүйцэтгүүлж болно.				
3.6	14.6.3. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд улируулан эсхүл шинээр сонгуулахаар нэр дэвшүүлэх;				
3.7	19.2. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ-ийн хуралд оролцсон саналын эрхтэй, сонирхлын зөрчилгүй гишүүд 100 хувь санал нэгтгэйгээр гаргана. ТУЗ их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтгэйгээр гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.				
3.8	20.6. Компани нь дараах тохиолдолд Сонирхлын зөрчилтэй хэлцэл /хоорондоо уялдаатай хэд хэдэн хэлцэл/ хийх, хараат болон охин компанид сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор гаргана:				
3.9	22.2.Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл				

	Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу эргүүлэн худалдан авч болох бөгөөд энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.				
3.10	22.3.Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь худалдан авч болно.				
4.1	Өөрийн хөрөнгийг 5.0 тэрбум хүртэл төгрөгийн хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэхийг зөвшөөрөх				
4.2	Хоёрдогч өглөгийн нөхцөлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу батлах болон гэрээ байгуулах асуудлыг шийдвэрлэх эрхийг Компанийн ТУЗ-д олгох				

Хувьцаа эзэмшигч иргэн:

Гарын үсэг: _____
Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон төлөөлөгч:

Гарын үсэг: _____
Албан тушаал: _____

Брокерийн гарын үсэг (тамга): _____
Саналын хуудас хүлээн авсан огноо, цаг: _____

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын Дарга: _____
Гишүүн: _____
Гишүүн: _____

Хэрэв хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

Санал авах хуудас ашиглах дараахь санамжтай танилцана уу!

Санал авах хуудас ашиглах санамж

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгтээ (+) тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (+), татгалзсан, эсхүл түдгэлзсэн бол харгалзах нүдэнд (+) тэмдэг тавина.

2. Санал авах хуудасны эхний хэсгийг зуучлагч үнэт цаасны компанийн тэмдэг даран баталгаажуулж хувьцаа эзэмшигчдэд өгнө.
3. Засварласан, балласан болон залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хувьцаа эзэмшигчид нь 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн дотор хурлын материалтай танилцах бөгөөд хэрэв Та хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол санал авах хуудсанд саналаа тэмдэглэн, үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 18.00 цагаас өмнө хүргүүлнэ.
5. Хэрэв Та саналаа итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэх бол итгэмжлэгдсэн этгээдийн мэдээллийг дор бичин итгэмжлэлийн хамт саналын хуудсыг ирүүлнэ үү.

Таныг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлэл

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр:

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн регистрийн дугаар:

Хувьцаа эзэмшигч буюу таны нэр: _____

Таны эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг):

Гарын үсэг: _____

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 2 сарын 03-ны өдрийн 20/09 тоот тогтоолын
ХАВСРАЛТ №56



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа бол:

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр, регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: **Энгийн**

Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг): _____

Санал хураах арга: **Кумулятив**

Тайлбар: ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгож, бүрэн эрхийн хугацааг сунгахад таны өгөх нийт саналын эрхийн тоо нь таны эзэмшиж буй хувьцааны тоог улируулан сонгох ТУЗ-ийн гишүүдийн тоо буюу 8-аар үржүүлсэнтэй тэнцэх бөгөөд энэхүү тоо нь үүнээс их болон бага байх тохиолдолд таны санал хүчингүйд тооцогдохыг анхаарна уу.

Кумулятив аргаар санал хураах жишээ:

Хэрэв та 100 ширхэг хувьцаа эзэмшдэг бол таны өгөх нийт санал нь ТУЗ-ийн улируулан сонгох гишүүдийн тоо буюу 8-г таны эзэмшиж буй хувьцааны тоо буюу 100-аар үржүүлж нийт 800 саналын эрхтэй. Үүний 400 саналын эрхийг ТУЗ-ийн ердийн 4 гишүүнд, 300 саналын эрхийг ТУЗ-ийн хараат бус 3 гишүүнд тус тус 3 хувааж өгнө. Гэхдээ 400 саналын эрхээ ТУЗ-ийн ердийн 4 гишүүнд хувааж өгч болохоос гадна, тодорхой нэг эсвэл хэд хэдэн гишүүнд хуваан өгч болно. Мөн 300 саналын эрхээ тодорхой нэг, эсхүл ТУЗ-ийн 3 хараат бус гишүүнд хувааж өгч болно. Харин таны нийт саналын эрхийн тоо 800-с их буюу бага байж болохгүй.

№	Хэлэлцэх асуудал	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Саналын эрхийн тоо
1	ТУЗ-ийн ердийн гишүүнийг улираан сонгох	ТУЗ-ийн ердийн гишүүн Очирсүрэнгийн БОЛДБААТАР	
		ТУЗ-ийн ердийн гишүүн Володягийн БАЯРСАЙХАН	
		ТУЗ-ийн ердийн гишүүн Баянжаргалын ДЭЛГЭРЖАРГАЛ	
		ТУЗ-ийн ердийн гишүүн Нармандахын ЦЭВЭГМИД	
		ТУЗ-ийн ердийн гишүүн Сэнгээгийн ЭНХ-АМГАЛАН	
2	ТУЗ-ийн хараат бус гишүүнийг улираан сонгох	ТУЗ-ийн хараат бус гишүүн Сүрэнхүүгийн БОРГИЛ	
		ТУЗ-ийн хараат бус гишүүн Жигдэнгийн ЖАРГАЛСҮРЭН	
		ТУЗ-ийн хараат бус гишүүн Чинбатын НОМИН	

3	Нийт саналын эрхийн тоо	
---	-------------------------	--

Хувьцаа эзэмшигч иргэн:

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг
төлөөлж хуралд оролцсон төлөөлөгч:

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

Албан тушаал: _____

Брокерийн гарын үсэг (тамга): _____

Саналын хуудас хүлээн авсан огноо, цаг: _____

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын Дарга: _____

Гишүүн: _____

Гишүүн: _____

Хэрэв хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 2 сарын 03-ны өдрийн 26/сз тоот тогтоолын
ХАВСРАЛТ №5в



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа бол:

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр, регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: **Энгийн**

Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг): _____

Санал хураах арга: **Кумулятив**

Тайлбар: ТУЗ-ийн гишүүн сонгоход таны өгөх нийт саналын эрхийн тоо нь эзэмшиж буй хувьцааны тоог ТУЗ-ийн шинээр сонгох гишүүдийн тоо (1)-оор үржүүлсэнтэй тэнцэх бөгөөд энэхүү тоо нь үүнээс их болон бага байх тохиолдолд таны санал хүчингүйд тооцогдохыг анхаарна уу.

Кумулятив аргаар санал хураах жишээ:

Хэрэв та 100 ширхэг хувьцаа эзэмшдэг бол таны өгөх нийт санал нь шинээр сонгох ТУЗ-ийн гишүүний тоо буюу 1-ыг таны эзэмшиж буй хувьцааны тоо буюу 100-аар үржүүлж нийт 100 саналын эрхтэй. Өөрийн 100 саналын эрхийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох нэр дэвшигчид өгнө. Харин таны нийт саналын эрхийн тоо 100-с их буюу бага байж болохгүй.

№	Хэлэлцэх асуудал	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Саналын эрхийн тоо
1	ТУЗ-ийн ердийн гишүүнийг сонгох	ТУЗ-ийн ердийн гишүүнээр Цэвэгжавын ОДМААГ сонгосугай.	
2	Нийт саналын эрхийн тоо		

Хувьцаа эзэмшигч иргэн:

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг
төлөөлж хуралд оролцсон төлөөлөгч:

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____
Албан тушаал: _____

Брокерийн гарын үсэг (тамга): _____

Саналын хуудас хүлээн авсан огноо, цаг: _____

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын Дарга: _____

Гишүүн: _____

Гишүүн: _____

Хэрэв хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____
